

Танилцуулга

Авто үйлчилгээ эрхлэгч байгууллага,
иргэдийн үйл ажиллагаанд тандалт
судалгаа хийсэн тухай

2016.06.21

Улаанбаатар хот

Нэг. Тандалт судалгааны зорилго

Зам, тээврийн яам болон МХЕГ-ын 2016 онд хамтран ажиллах төлөвлөгөө, МХЕГ-ын даргын баталсан 2016 оны 01/06 дугаартай удирдамжийг тус тус үндэслэн ХШҮДАГ-ын даргын баталсан 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 38-07-076/21 дугаар бүхий удирдамжийн дагуу авто үйлчилгээ эрхлэгч байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хүний амь нас, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйл байгаа эсэхийг тодорхойлж, авто үйлчилгээний мэдээллийн сан болох “Үйлчилгээ-Оношлогоо-Хяналтын нэгдсэн систем”-ийг баяжуулах, эрсдэл бууруулах арга хэмжээ авах санал боловсруулахад тандалт судалгааны зорилго оршино.

Хоёр. Тандалт судалгаа хийх бүрэлдэхүүн, хугацаа

Зам, тээврийн яамны ХШҮДАГ-ын Зам, тээврийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн, улсын байцаагч Н.Уугандулам, тус хэлтсийн Зам, тээврийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт хариуцсан мэргэжилтэн Г.Тэмүүлээ болон аймгуудын автотээврийн хяналтын улсын байцаагч нар хамтран 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн ажлын 15 хоногт багтаан гүйцэтгэлээ.

Гурав. Тандалт судалгаанд хамрагдсан байгууллага, иргэдийн талаар

Тандалт судалгаанд нийт 147 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан байна. Үүнээс Нийслэлийн 7 дүүргийн авто засварын 13 байгууллага, 55 иргэн, сэлбэг, худалдааны-3 иргэн, дугуй засварын-5 иргэн, аймаг, орон нутгийг авто засварын 31 иргэн, 10 байгууллага, дугуй засварын үйл ажиллагаа эрхлэгч 30 иргэн тус тус хамрагдсан нь улсын хэмжээнд нийт авто үйлчилгээ эрхлэгчидийн 7% /нийслэлийн 8%, аймгийн 6%/-д тандалт судалгаа хийсэн байна.

Тандалт судалгааг:

1. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн мэдээллийг үндэслэн авто үйлчилгээ эрхлэгчидийн ерөнхий судалгааг /Хүснэгт 1, Хүснэгт 2-т/ гаргасан.

Хүснэгт 1: 21 аймагт авто үйлчилгээ эрхлэгч байгууллага, иргэдийн тоо

	Аймаг	Авто засвар	Дугуй засвар	Авто угаалга	Сэлбэг, худалдаа	Тос	Нийт
1	Архангай	4	43	2	22	1	72
2	Баян-Өлгий	28	7	0	20	5	60
3	Баянхонгор	76	12	10	5	8	111
4	Булган	6	35	1	5	2	49
5	Говь-Алтай	15	22	5	23	20	85

6	Говьсүмбэр	2	3	0	4	9	18
7	Дархан-Уул	7	7	1	1	2	18
8	Дорноговь	23	28	5	10	13	79
9	Дорнод	14	23	4	6	2	49
10	Дундговь	8	21	2	4	5	40
11	Завхан	1	11	2	8	4	26
12	Орхон	22	6	11	10	5	54
13	Өвөрхангай	18	48	8	22	26	122
14	Өмнөговь	23	41	20	39	14	137
15	Сүхбаатар	5	14	1	11	3	34
16	Сэлэнгэ	11	38	6	13	2	70
17	Төв	8	47	4	22	6	87
18	Увс	3					3
19	Ховд	Мэдээлэл ирээгүй					
20	Хөвсгөл	9	11	9	27	10	66
21	Хэнтий	22	32	2	17	3	76
Нийт		305	449	93	269	140	1256

Дээрх хүснэгтээс харахад авто үйлчилгээ эрхлэгч нийт 1256 иргэд, байгууллагаас дугуй засварын-449 (36%), авто засварын-305 (24%), сэлбэг, худалдааны-269 (21%), тос, тослох материалын худалдаа эрхлэгч-140 (11%) болон авто угаалга-93 (7%) иргэн, байгууллага байгаагаас **Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор** аймгуудад авто үйлчилгээ эрхлэгчид 370 (30%) олонхи байна.

Хүснэгт 2: Нийслэлд авто үйлчилгээ эрхлэгч байгууллага, иргэдийн тоо

	Дүүрэг	Авто засвар	Дугуй засвар	Авто угаалга	Сэлбэг, худалдаа	Тос	Нийт
1	Баянзүрх	133	45	39	38	17	272
2	Баянгол	76	16	39	27	15	173
3	Чингэлтэй	83	29	12	17	8	149
4	Сүхбаатар	73	12	22	27	2	136
5	Сонгинохайрхан	44	25	17	24	4	114
6	Хан-Уул	13	25	13	10	5	66
7	Налайх	6	17	3	3	1	30
8	Багануур	9	4	6	3	1	23
9	Багахангай	1	1	0	0	1	3
Нийт		438	174	151	149	54	966

Нийслэлд авто үйлчилгээ эрхлэгчидийн тоогоор **Баянзүрх** дүүрэг тэргүүлж байгаа ба авто засварын 45%-иас 30% буюу 133 нь уг дүүрэгт байна. Бусад дугуй засварын-174 (18%), авто угаалга-151 (16%), сэлбэг, худалдааны-149 (16%) ба тос, тослох материалын худалдаа эрхлэгч 54 (6%) байна.



График1: Улсын хэмжээнд авто үйлчилгээ эрхлэгчидийн эзлэх хувь

Улсын хэмжээнд авто үйлчилгээ эрхэлж буй нийт 2222 иргэд, байгууллагын 20% нь аж ахуйн нэгж, 80% хувь хүн иргэн байна.

2. Нийслэлд авто засварын үйл ажиллагаа эрхлэгч нийт 438 иргэн, байгууллагын 68 буюу 16%-д тандалт судалгаа хийгдсэн.

2.1. Албан ёсны төлөөлөгчийн компани-4 (6%).

Монгол улс дахь албан ёсны дистербьютер болох “Вагнер Ази Автомотив” ХХК, “Таванбогд Евро Автомотив” ХХК-иуд нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, стандартыг хангах талаар хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах, гэмтлээс урьдчилан сэргийлэх замаар ажиллаж байна.

Тухайн байгууллагууд нь мэргэжлийн боловсон хүчин бүхий засварын багтай, засвар үйлчилгээний байр нь холбогдох стандартын шаардлага хангасан, ажлын байрны нөхцлийн үнэлгээ гаргуулсан байна.



“Таванбогд Евро Автомотив” ХХК, “Хүдэрмөнх” ХХК-ийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа

2.2. Авто үйлчилгээний төвийн үйл ажиллагааг нэгдсэн цогц(засвар, сэлбэг, тос) хэлбэрээр эрхэлж буй-9 (13%) байгууллага;

“Дельта авто сервис” ХХК, “Доктор авто сүлжээ” ХХК, “Буянт Оюу” ХХК-иуд нь 3-5 салбартай байх ба салбар бүр тодорхой нэг үйлчилгээгээр дагнасан/агрегат, тос солих гэх мэт/, автотээврийн мэргэжил бүхий засварын ажилчидтай, байгууллагын ерөнхий менежер нь ажилчидын ур чадварыг дээшлүүлэх талаар сургалт, дадлагажуулах ажлыг хариуцан холбогдох хууль, стандартын дагуу хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг ханган ажиллуулж байна.

Тоног төхөөрөмжийг Итали, Япон, Солонгос улсын компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, нийлүүлсэн ба тэдгээртэй ажиллах техникийн зааварчилгааг монгол хэл рүү хөрвүүлэн орчуулсан, өдөр тутам хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, зөвлөмж өгч байна.



2.3. Авто үйлчилгээний төвийн үйл ажиллагааг төрөлжсөн буюу жижиг хэлбэрээр явуулж буй-55 (81%) иргэн, байгууллага байна. Нийт 438 авто засвараас кузов засвар гэсэн нь 174 буюу 41% байна.

Төрөлжсөн буюу жижиг хэлбэрээр авто үйлчилгээг эрхэлж буй иргэд, байгууллагуудын үйл ажиллагаа нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангалтгүй, хууль, дүрэм, журам, стандартыг хангахгүй, гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй байна.

Мөн ажилчидын 65% нь автотээврийн мэргэжилгүй, мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, гэрчилгээ аваагүй байна. Тухайн засварын газрыг иргэд өөрсдөө ажиллуулдаг ба тэд цаашид сургалт, танилцуулах хөтөлбөрт хамрагдах сонирхолтой байгаагаа судалгааны явцад илэрхийлсэн.

2.4 Аймаг болон нийслэлд авто засварын жижиг хэлбэр, дугуй засварын үйлчилгээ явуулж буй иргэд, байгууллагын байр нь ижил нөхцөлд байгааг дараах зураг харуулж байна.



Сүхбаатар аймгийн авто засвар



Чингэлтэй дүүргийн авто засвар



Архангай аймгийн дугуй задлагч



Налайх дүүргийн дугуй задлагч

2.5 “Үйлчилгээ-Оношлогоо-Хяналтын нэгдсэн систем”-ийн хүрээнд нийслэлд авто үйлчилгээ эрхлэгч 966 иргэн, байгууллагын мэдээлэл бүхий EXCEL санг үүсгэсэн.

Дөрөв. Тандалт судалгааны явцад хийгдсэн ажил

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, стандартыг хангах, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх зэрэг мэргэжлийн болон хууль эрх зүйн “зөвлөмж” өгөх замаар эрсдэлээс урьдчилан сэргийлүүлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээ авч ажиллаа.


Тав. Аж ахуйн нэгж, байгууллагуудын ололттой, дэвшилттэй тал

Тандалт судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн үйл ажиллагаанд дараах ололттой талууд байна. Үүнд:

5.1. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын авто үйлчилгээ эрхлэгч 5 байгууллага, 2 иргэн Автотээврийн тухай хуулийн 19².3.5-д заасны дагуу 2014, 2015 онуудад ангилалаа тогтоолгосон;

5.2. “Дельта авто сервис” ХХК нь Хөдөлмөрийн яам болон Монгол Солонгосын хамтарсан Техникийн коллежтой байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд кузов засварын чиглэлээр инженер, техникийн ангийн оюутнуудыг өөрийн ажлын байранд дадлага хийлгэж байгаа;

5.3. Авто үйлчилгээний төвийн үйл ажиллагааг цогцоор явуулж буй “Доктор авто сүлжээ” ХХК, “Буянт Оюу” ХХК, “Дельта авто сервис” ХХК-иуд хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн, ажилтнуудад аюулгүй ажиллагааны гурван шатны зааварчилгааг өдөр бүр өгч, хөдөлмөр хамгааллын үзлэгийн дэвтэрт тэмдэглэл хөтөлж, зөвлөмж тогтмол өгч хэвшсэн;



5.4 Таван богд Евро Автомотив” ХХК нь ЕТКА-сэлбэгийн захиалга, ODIS-оношлогооны програм хангамжуудыг өдөр тутам ашиглаж байгаа ба “Үйлчилгээ-Оношлогоо-Хяналтын нэгдсэн сан”-тай дүйцэхүйц “ELSA pro” сүлжээг засварын үйлчилгээнд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа;

5.5 “Доктор авто сүлжээ” ХХК болон “Дельта авто сервис” ХХК-иуд нь хэрэглэгчидийн талаарх өөрсдийн мэдээллийн “CRM” сүлжээтэй байна.

Зургаа. Авто үйлчилгээ эрхлэгч байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд илэрсэн нийтлэг зөрчил, дутагдал

6.1. Авто үйлчилгээ эрхлэгч иргэд, байгууллагын ажилчидын 98% нь Автотээврийн тухай хуулийн талаарх мэдлэг дутмаг тул 19².3.2-д заасны дагуу тухайн жилд үйлчлүүлсэн хэрэглэгчийн талаарх судалгааг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгдөггүй;

6.2. Авто үйлчилгээ эрхлэгч иргэд, байгууллагын 2% нь 2010-2014 онуудад Автотээврийн тухай хуулийн 19².3.5-д заасны дагуу эрх бүхий байгууллагаар ангилалаа тогтоолгосон боловч хугацааг сунгуулаагүй;

6.3. Аймагт авто үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд тухайн аймгийн Засаг даргын тамгын газраас Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл, гэрээ байгуулаагүй;

6.4. Байрны өмчлөлийн хэлбэр 40% түрээс, 60% өөрийн байна. АСЕМ-11 уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд ОБЕГ-аас тэдгээрийн галын аюулгүй байдлыг хангасан эсэхийг шалгаж, дүгнэлт гаргасан байна. Харин алслагдсан дүүрэг болох Налайхын засварын газрын 80% нь галын хорыг байрлуулсан боловч эрсдэлээс сэргийлэх булан, самбаргүй;



Нийслэл дэх ААНБ-ын галын булан

Налайхын авто засварын газар

6.5. “Авто үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага” MNS5025:2010 улсын стандартын дагуу техникийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын заавар, зааварчилгааг боловсруулж, мөрдөж, ажилладаггүй;

6.6. Авто үйлчилгээний ажилтнууд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаагүй;

6.7. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл тогтмол өмсөж хэвшээгүй;

6.8. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу үйлчилгээ эрхэлж буй иргэд, байгууллагууд нь хаягдал тос болон хогыг тогтмол цэвэрлэх талаар ямар нэг арга хэмжээ аваагүй.

Долоо. Дүгнэлт

7.1 Авто засварын үйлчилгээ эрхлэгчидээс албан ёсны төлөөлөгчийн компани болон авто үйлчилгээний төвийн үйл ажиллагааг нэгдсэн цогц(засвар, сэлбэг, тос) хэлбэрээр эрхэлж буй компаниуд нь холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг мөрдөн ажиллаж байна.

7.2 Авто засварын төрөлжсөн буюу жижиг хэлбэрээр үйлчилгээ эрхэлж буй иргэд, байгууллагуудын 41% нь кузов засвар, үлдсэн 59% нь бусад засварын газар байгаагаас 58% нь засвар үйлчилгээ хийх 2-3 ашиглагдсан, эрх бүхий байгууллагаар баталгаажуулалт хийлгэсэн тоног төхөөрөмжтэй байгаа нь засвар үйлчилгээг зохих түвшинд хийж байна.

7.3 Нийт авто засварын газруудын 88% нь хийсэн засвар үйлчилгээнээс хамаарч 7 хоногоос 1 жил хүртэлх хугацааны баталгаа гаргаж байгаа нь “Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам”-ын 3.4, 3.5 заалтуудыг мөрдөн ажиллаж байна.

7.4 Авто засварын төрөлжсөн буюу жижиг хэлбэрээр үйлчилгээ эрхэлж буй иргэд, байгууллагууд нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны гурван шатны зааварчилгааг ажилчдад тогтмол өгч ажилладаггүй нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах боломжгүй байна.

7.5 Авто үйлчилгээ эрхлэгч албан ёсны дистербьютер болон нэгдсэн цогц үйлчилгээ явуулж буй байгууллагууд нь мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байхад жижиг засварын газруудын ажилчид мэргэжлийн бус, мэргэшүүлэх сургалтад хамрагдаагүй байгаа нь “Авто үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага” MNS5025:2010 улсын стандартын 11.1-д заасныг хангахгүй байна.

Найм. Цаашид авах арга хэмжээний санал

АЗТБХЗГ-ын Авто тээврийн хэлтэст:

7.1. Аймаг болон Нийслэлд авто үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын удирдах ажилтан нарт Автотээврийн тухай хууль болон холбогдох журам, хөдөлмөр хамгаалал, ажлын байрны нөхцлийн үнэлгээний талаар танилцуулга, сургалт, сурталчилгааг МХЕГ, НТГ болон “АТУТ” ТӨҮГ-тай хамтран зохион байгуулах;

7.2. ЗТС-ын 2015 оны 204 дүгээр тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд авто үйлчилгээтэй холбоотой ажлуудыг эрчимжүүлэх;

7.3. ХЗЯ-ны Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн “Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам”, “Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам”-ыг хэрэгжүүлэх;

7.4. Аймгийн Засаг даргын тамгын газрын холбогдох мэргэжилтэнд авто үйлчилгээ эрхлэгч иргэд, байгууллага Үйлчилгээ эрхлэх гэрээг байгуулах талаар зөвлөмж өгөх;

7.5. Нийслэлд авто засварын үйлчилгээ эрхэлж буй 438 иргэд, байгууллагын холбогдох ажилтан нарт “МИАТ” ТӨХК-ийн Засварын газрын үйл ажиллагааг танилцуулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулах;

ХШҮДАГ-ын Зам, тээврийн хяналтын хэлтэс:

7.6. Авто үйлчилгээ эрхлэгч байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг МХЕГ, НМХГ, НТГ-тай хамтран хэрэгжүүлэх;

7.7. Авто үйлчилгээ эрхлэгч байгууллага, иргэдэд хийсэн тандалт судалгааны танилцуулгыг холбогдох газарт хүргүүлэх.

---o0o---